



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН



Монгол цэрэг энхийн үйлсэд

## ДОЛООН ЖИЛИЙН ХУГАЦААНД 544 ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ ҮҮРГЭЭ НЭР ТӨРТЭЙ, АМЖИЛТТАЙ ГҮЙЦЭТГЭЖЭЭ

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Бүгд Найрамдах Судан Улсад явагдсан НҮБ болон Африкийн холбооны хамтарсан UNAMID ажиллагааны цэргийн хэргийн II шатны эмнэлгийн үүрэг гүйцэтгэлт, туршлага, сургамжийн талаарх хэлэлцүүлэг өнөөдөр УБХИС-ийн "Сүбээдэй" танхимд болж байна.

Тус хэлэлцүүлэгт ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал С.Ганбямба, АУГ-ын дарга бригадын генерал С.Дашзэвэг, БСТГ-ын дарга бригадын генерал Ц.Гандорж, ЭМЯ-ны СБТГ-ын дарга Б.Буянтогтох, ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтсийн дарга хурандаа Т.Сүхбаатар болон UNAMID ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид оролцож байна. Бүгд Найрамдах Судан Улсад явагдсан НҮБ болон Африкийн холбооны хамтарсан UNAMID ажиллагаа нь Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 4,2 сая америк долларын өртөг бүхий "Цэргийн хэргийн хөдөлгөөнт II шатны эмнэлэг"-ийг 2008 онд хүлээн авч, Судан улсын Дарфур мужид зохион байгуулагдаж буй энхийг дэмжих ажиллагаанд "Цэргийн хэргийн II шатны эмнэлэг" бэлтгэн оролцуулах асуудлыг боловсруулан, ЗХЖШ-ын даргын зөвлөл, Батлан Хамгаалахын сайдын зөвлөл, Монгол



Улсын Засгийн газрын хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, үе шаттайгаар шийдвэрлүүлэн "Энхийг сахиулах ажиллагаанд цэргийн хэргийн II шатны эмнэлгийн баг оролцуулах тухай" Засгийн газрын 2010 оны 62 дугаар тогтоол, "Ажиллагааны бэлтгэлийг хангах тухай" Батлан хамгаалахын сайдын 2010 оны 142 дугаар, "Ажиллагааны өмнөх бэлтгэлийг

зохион байгуулах тухай" ЗХЖШ-ын даргын 2010 оны 357 дугаар тушаалууд тус тус гарч, цэргийн хэргийн II шатны эмнэлгийн эхний ээлжийн цэргийн багийн ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтыг ханган, ажиллагааны газар орон руу илгээж, 2010 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж эхэлсэн юм. Монгол

Улсын Цэргийн хэргийн II шатны эмнэлэг нь НҮБ-тай байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ээр Судан улсын Дарфур муж дахь НҮБ, Африкийн холбооны хамтарсан UNAMID ажиллагааны Хойд бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа 5300 гаруй НҮБ-ын цэрэг, цагдаа болон энгийн ажилчин албан хаагчдад эмнэлгийн анхан болон хоёр дахь

шатны тусламж, яаралтай сэхээн амьдруулах арга хэмжээ, ерөнхий болон хэсгийн мэдээ алдуулалтын дор амь нас аврах заалтаар хийгдэх мэс засал, амбулатори, хэвтүүлэн эмчлэх, шархтныг ажиллагааны хариуцлагын бүсийн дотор болон гадна байрлах дараагийн шатны /III шатны/ эмнэлгийн байгууллага руу татан гаргах үндсэн үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Ийнхүү тус ажиллагаа нь 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдөр НҮБ-ын төв штабаас гаргасан шийдвэр, UNAMID ажиллагааны Хүчний командлагчийн гаргасан 2017 оны 11 дүгээр сарын 02-ны тушаалаар Судан улсын Дарфур муж дахь НҮБ, Африкийн холбооны хамтарсан UNAMID ажиллагааны Хүч бүсийн Какабияа сууринд үүрэг гүйцэтгэж байсан Монгол Улсын цэргийн хэргийн II шатны эмнэлгийн багийн үйл ажиллагааг 2017 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр дуусгаар болгон эх оронд нь буцаах албан ёсны шийдвэр гарснаар үүрэг гүйцэтгэлт өндөрлөсөн билээ. Энэхүү ажиллагаа үргэлжилсэн долоон жилийн хугацаанд 8 удаагийн цэргийн багийн ээлжинд нийт 544 цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй, амжилттай гүйцэтгэсэн юм.

Тус ажиллагааны үүрэг гүйцэтгэлт, туршлага, сургамж талаарх хэлэлцүүлэгт тавигдсан 7 үндсэн илтгэлийг доор тоймлон хүргэж байна.

### ХУРАНДАА Т.СҮХБААТАР: БҮГД НАЙРАМДАХ СУДАН УЛСЫН ДАРФУР МУЖИД ЯВАГДАЖ БҮЙ НҮБ, АФРИКИЙН ХОЛБООНЫ ХАМТАРСАН "UNAMID" ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН ХЭЭРИЙН II ШАТНЫ ЭМНЭЛГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН, ТУРШЛАГА, СУРГАМЖ

#### Агуулга:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллага, Африкийн холбооны хамтарсан "UNAMID" ажиллагааны товч танилцуулга
2. UNAMID ажиллагаанд Монгол Улсын цэргийн хэргийн II шатны эмнэлгийн оролцооны талаар:
3. Монгол Улсын цэргийн хэргийн II шатны эмнэлгийн үндсэн үүрэг гүйцэтгэлтийн талаар:
4. Туршлага, сургамж, хангалт, бусад ажлын талаар:
5. Таг. НҮБ-н Энхийг сахиулах ажиллагаанд шинээр эмнэлэг дэлгэх

Монгол Улсын Зэвсэгт хүчин 2002 оноос эхлэн офицеруудад "НҮБ-ын цэргийн ажиллагч"-ийн статустайгаар илгээж эхэлснээс хойш өдгөө 16 дахь жилийн нур үеэ, үүрэг гүйцэтгэсэн ажиллагаа тус бүрээс туршлага, сургамж хуримтуулсаар байна. Тус UNAMID ажиллагаанд Монгол Улсын цэргийн хэргийн II шатны эмнэлгийн 8 ээлжийн баг 7 жил гаруй хугацаанд үүрэг гүйцэтгэснээр дараах арвин туршлагыг хуримтуулсан гэж үзэж байна. Үүнд:

1. Цэргийн хэргийн II шатны эмнэлгийн бүрэлдэхүүнийг ажиллагааны газар оронд үүсэж болохгүй цагийн байдлын аян бүрийн нөхцөлд олонорой гэмтээх, бүртгэн өвчтөн шартанд эмнэлгийн тусламж үзүүлэх, ялангуяа дагалдаж, тэвэрлэх, татан гаргалт зохион байгуулах дадала, сургуульд тогтмол хамруулж байсан нь бүрэлдэхүүн ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байх хугацаанд нэгэн зэрэг олонорой гэмтсэн осол, гэмтлийн болон галт зэвсгийн шархтай өвчтөн шартнуудад эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг богино хугацаанд үр дүнтэй үзүүлэх, эмнэлгийн бүрэлдэхүүний цагийн байдлын хүндрүүлсэн нөхцөлд ч багаар ажиллах чадвар, дадалыг дэхүүнүүлсэн.

Сургамж:  
1. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх эмч нарын хүрээлэх, болонмийг нэмэгдүүлэхийн тулд Зэвсэгт хүчинд ажилдаг нарийн мэргэжлийн эмч, сувиллагч, эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчдийн тоог нэмэгдүүлэх;

2. Цэргийн баг тус бүрд англи хэлний зохих шатны мэдлэгтэй эмч, сувиллагч нарын ээлж хуви маш бага (30-40%) байсан нь НҮБ-ын алба хаагчдад эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх тал дээр хүндрэл гарч байсан. Иймд эмч, эмнэлгийн мэргэжилтний англи хэлний сургалтыг урьдчилан зохион байгуулж, гадаад хэлний мэдлэгтэй эмнэлгийн мэргэжилтний ээлж хуви нэмэгдүүлэх;

3. Цэргийн багт үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтыг 1-2 жилийн өмнөх хийж, бие бялдур, сэтгэл зүй, гадаад хэл, мэргэжлийн бэлтгэлтэй тусгай төлөвөгөө гарган хянуулж, ажиллагааны газар оронд ашиглагдах эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмж дээр ажиллах дадалыг нэмэгдүүлэх, нэг эмнэлгийн мэргэжилтэн нөгөөгөө оронд үүрэг гүйцэтгэх чадвартай болгох, цэргийн багийн удирдах бүрэлдэхүүний манлайлах чадвар, багийн удирдлагын гар нийлэмжтэй ажиллагааг сайжруулах;

4. Цэргийн багт үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний сонгон шалгаруулалт, үүрэг гүйцэтгэлт;

1. Үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтыг 1-2 жилийн өмнөх хийж, бие бялдур, сэтгэл зүй, гадаад хэл, мэргэжлийн бэлтгэлтэй тусгай төлөвөгөө гарган хянуулж, ажиллагааны газар оронд ашиглагдах эмнэлгийн аппарат, тоног төхөөрөмж дээр ажиллах дадалыг нэмэгдүүлэх, нэг эмнэлгийн мэргэжилтэн нөгөөгөө оронд үүрэг гүйцэтгэх чадвартай болгох, цэргийн багийн удирдах бүрэлдэхүүний манлайлах чадвар, багийн удирдлагын гар нийлэмжтэй ажиллагааг сайжруулах;

2. Бие бүрэлдэхүүний цэргийн баг гүйцэтгэх үүргийг нарийн судуулах, дадалаагуулах, үүрэг гүйцэтгэх гэрээнд үүргийг нь тодорхой тусган оруулах;

3. Цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн нийт бүрэлдэхүүний 58,1 хувь эмч, эмнэлгийн мэргэжилтний 65,4 хувь нь эмзэгтэй цэргийн алба хаагч байсан нь "UNAMID" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байсан хамгийн олон эмзэгтэй цэргийн алба хаагчтай, НҮБ-аас хүйсийн тэгш байдлын талаар бэрхж байгаа бодлогыг хамгийн сайн дэмжсэн цэргийн баг байсан. Дахин II шатны эмнэлэг дэргэн байгуулбал цэргийн багийн эмчийн болон судлийн ээлжид эрэгтэй цэргийн алба хаагчдын ээлж хуви нэмэгдүүлэх шаардлагатай. Цэргийн багийн долоодугаар ээлжийн захиргаанаар эмзэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн, цаашид ч цэргийн багийн захиргаанаар эмзэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэх боломжтой харуулсан.

4. Цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүний 12-20 хүртэл хувь нь 40-45 насны, 4 хувь нь 46-аас дээш насны цэргийн алба хаагчид эзлэх байсан, цаашид эмнэлгийн багт нас болон хүйсийн байдлаас илүүтэйгээр мэргэжлийн үр чадвар, гадаад хэлний мэдлэгтэй цэргийн багийн эмчийн болон судлийн ээлжид эрэгтэй цэргийн алба хаагчдын ээлж хуви нэмэгдүүлэх шаардлагатай. Цэргийн багийн долоодугаар ээлжийн захиргаанаар эмзэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн, цаашид ч цэргийн багийн захиргаанаар эмзэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэх боломжтой харуулсан.

5. Цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүний 12-20 хүртэл хувь нь 40-45 насны, 4 хувь нь 46-аас дээш насны цэргийн алба хаагчид эзлэх байсан, цаашид эмнэлгийн багт нас болон хүйсийн байдлаас илүүтэйгээр мэргэжлийн үр чадвар, гадаад хэлний мэдлэгтэй цэргийн багийн эмчийн болон судлийн ээлжид эрэгтэй цэргийн алба хаагчдын ээлж хуви нэмэгдүүлэх шаардлагатай. Цэргийн багийн долоодугаар ээлжийн захиргаанаар эмзэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн, цаашид ч цэргийн багийн захиргаанаар эмзэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэх боломжтой харуулсан.

6. Эх орондоо ажил үүрэг гүйцэтгэж буй эмч, сувиллагч нар тодорхой багц цагийн сургалтад хамрагдаж, нэг жилд нэг эмч 6 кредит, нэг сувиллагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 3 кредитийн багц цагийг биелүүлж, тасралтгүй 5 жилд эмч 30 кредит, сувиллагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 15 кредит цуглуулж эмчлэх болон сувиллах эрхийн лицензээ сунгуулдаг. Ажиллагааны газар орон дээр эмч, сувиллагч эмнэлгийн тусгай мэргэжилтэнд эмнэлгийн дотоод сургалтаг явуулдаг боловч кредит олгох боломжгүй, тухай хийсэн сургалтын багц цаг тар хийгдэх хүчинтэй зэргээс хамааран эмч, сувиллагч, тусгай мэргэжилтэн нэг жилийн хугацаанд үүрэг гүйцэтгэхэд багц цагаа биелүүлж чадахгүй хүрч улмаар лицензээ сунгуулдаг болхонд тулгардаг тул ЭМХТТ-ийг аамтран ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн хугацааны кредитийн асуудлыг шийдвэрлэж байх нь зүйтэй.

7. Бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх гэрээнд ажиллагааны газар оронд гаргасан зөрчил, дутагдалыг тооцон, эх оронд нь буцаах хүртэл арга хэмжээ авдаг эрхийг цэргийн багийн захиргаанд өгч, хариуцлага тооцдог байх.

8. Ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүний нэг бүрчлэн үнэлгээ үзлэгээр шалгуурыг шинээр бий болгож, цэргийн багийн захиргаа, дарга нараар үнэлүүлэн, үнэлгээ нь хувийн хэрэгт нь хадгалсан, дараагийн албан тушаалд томилоход, сургууль, энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтад нөлөөлдөг байх.

Бусад ажлын талаар:  
Цэргийн багийг ажиллагааны газар орноос татан гаргах ажлын талаар:

Судан Улсын Дарфур мужид явагдаж буй НҮБ, Африкийн холбооны хамтарсан энхийг сахиулах "UNAMID" ажиллагааны талаарх НҮБ-ын ЕНБД-ын стратегийн хэлэлцүүлэг, Африкийн холбооны комиссын даргын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр гаргасан тусгай илтгэлд: "UNAMID" ажиллагааны хэтийн төлөв байдлыг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх ба энэхүү 2 шатны үр дүнд нийт цэргийн алба хаагчдыг 44 хувь, цагдаагийн алба хаагчдыг 30 хувь хүртэл бууруулахаар төлөвлөсөн.

Тус төлөвлөлтийн дагуу UNAMID ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байсан Монгол Улсын цэргийн хэргийн II шатны эмнэлгийн багийн үйл ажиллагаа хааж, эх оронд нь буцаах шийдвэр гарсан ба шийдвэрийн дагуу үйл ажиллагаа явагдсан. Гэвч Монгол Улсын БХЯ, ЗХЖШ-ын хувьд энэ үйл ажиллагаа урьдчилан мэдээлэл авдаггүй дараагийн ээлжийн цэргийн багийн ажиллагааны өмнөх бэлтгэл сургалтыг явуулж, ажиллагаанд шаардлагад агуу материал, зарим хангалтыг зах зээлдээ худалдан авч нэлээдгүй төсөв хөрөнгө зарцуулсан үед UNAMID ажиллагаанд дараагийн ээлжийн эмнэлгийн цэргийн багийг хүлээн авалтгүй эх оронд нь буцаасан.

Эмнэлгийн багийг буцаах шийдвэр гаргах үед НҮБ-ын төв шат /Нью Йорк-т/ Монгол Улсаас төлөвлөн суух суурин төлөвөгч харахын томиолоогүй, мөн тус ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байсан штабын офицеруудын үүрэг гүйцэтгэлт 2017 оны 05 дугаар сард дуусч, эх орондоо буцаан, дараагийн ээлжийн штабын офицерууд ажиллагааны газар оронд 4 сар гаруй хугацааны дараа буцаж 2017 оны 09 дүгээр сард үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Энэ засварын хугацаанд Монгол Улсыг төлөөлөн ажиллагааны Хүчний штаб болон НҮБ-ын төв штабт удирдах элбэн тушаалын ажилтан байгаагүй нь тухайн мэдээлэл авалтаар үе гарсан шийдвэр тухай хууль эрх, зүйн зохицуулалт, заалт байхгүйгээс шалтгаалан Сангийн яам болон Гаалийн ерөнхий газарт цэргийн багийн ачааг татвар хураамжаас чөлөөлүүлэхэд хүндрэл учирч байгаа. Тухайлбал, татвар хураамжаас чөлөөлөх хууль, эрх зүйн үндэслэл байхгүйгээс шалтгаалан тус цэргийн багийн ачааг НҮБ-ээс БХЯ-нд үзүүлж буй буцалтгүй тусламж гэсэн нэрийн дор Сангийн яамнаас татвараас чөлөөлүүлэх тухай зөвшөөрлийг авсан.

2. Алливаа цэргийн багийг ажиллагааны газар орноос татан гаргах тогтоолын төслийг БХЯ, Засгийн газарт хургуулуудад хуралдаж чингэлсэн дугаартай ярих үеийн хураамжаас чөлөөлөх, гаалийн бүрдүүлэлт хийхэд дэмжлэг үзүүлж ажиллах Сангийн яам, Хил хамгаалах Ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллагууд дахвар үргэлжлүүлэн харилцан ажиллагаа хангах нь техник, эд хэрэгслийг саадгүй татан авахад дөхөм болох юм.

3. Цэргийн багийг ажиллагааны газар орноос татан авахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай зүйлийн нэг нь тухайн цэргийн багийн ачааг эх оронд нь буцаах бэлтгэл байх юм. Тухайлбал, тус цэргийн багийг ажиллагааны газар орноос татан гаргахад чингэлсэн дугаартай ярих үеийн хураамжаар ирсэн 2 ш чингэлэг /ус цэвэршүүлэгч/ стандарт бүс дугаартай зэргээс шалтгаалан манай ачаа БНХАУ-ын Тяньжинь боомтод гаалийн бүрдүүлэлт хийхэд хүндрэл учирч БНХАУ-ын тээвэр зүүний компанийн бие бүрэлдэхүүнээр чингэлгийн дугааруудыг шинээр бичүүлж чингэлэг дээр наалтасны дараа гаалийн бүрдүүлэлт хийгдсэн. Мөн АНУ-ын тусламжаар ирсэн дээрх 2 нэг чингэлэг стандарт бүс чингэлгийн дугаартай учир төмөр замын тээвэрээ тээвэрлэх боломжгүй болж тээвэрлэлтийг газаруу гүйцэтгүүлсэн.

4. БНХАУ-ын Тяньжинь боомтод 2015 онд болсон дэлбэрэлтээс шалтгаалан БНХАУ-ын нутгаар бүх төрлийн хий болон аюултай ачааг нэвтрүүлэхэд өндөр шаардлага тавьж, ийм төлийн ачааг дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл олгохоо больсон зэргээс шалтгаалан цэргийн багт ашиглагдаж байсан хийн баллон болон зарим төрлийн аюултай ачааг тухайн газар орон дээр ахлан устгах арга хэмжээг авсан нь дараа дараагийн цэргийн багийг татан гаргах, ажиллагааны газар оронд илгээхэд анхаарах асуудлын нэг юм.

5. Цэргийн багийн ачааг татан авахад БНХАУ-ын талас чингэлэгт тээвэрлэгдэн ирж зүйн хольцоны хэрэгсэлүүдийг техникчдийн гэрчилгээ, үйлдвэрлэсэн компани лиценз, уг хольцоны хэрэгсэлүүдийг ямар зориулалтаар ашигладаг талаар нэмэлт тодруула, баримт бичиг шаардаж гаалийн бүрдүүлэлт хийхэд хүндрэл учирч байсан тул холбооны хэрэгсэлүүдийг цэргийн багтай татан гаргаж буй нийлээг тээвэрлэх, шинээр цэргийн баг илгээхэд тендерээр худалдан авч буй хольцоны хэрэгсэлүүдийг хүлээн авахдаа тухайн компани албан ёсны лиценз, холбооны хэрэгслийн тухай холбогдох баримт бичгийг



бүрдүүлэн цэргийн багийг татан гаргах ажиллагаанд ашиглахаар хадгалах шаардлагатай байна. НҮБ-н Энхийг сахиулах ажиллагаанд шинээр эмнэлэг дэлгэх Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 10.5 дэх зүйлийн 1 дэх заалт, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалт, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.6, 8.1.7 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1, 10.5 дэх заалт, Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 8 дугаар зүйлийн 8.2.8, 8.3.3 дэх заалт, Зэвсэгт хүчний Жагшин штабын даргын зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн Монгол Улсаас НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд "Цэргийн хэргийн хоёрдугаар шатны эмнэлэг" оролцуулах боломжийг тодорхойлж, санал, тооцоо танилцуулж байна.

5.1. НҮБ-н Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй

Цэргийн эмнэлгийн өнөөгийн байдал  
НҮБ, Африкийн 7 улс орон (Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад UNMISS, Бурунди улсад ONUB, Либериа улсад UN-MIL, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад MONUSCO, Этиоп, Эритри улсуудад UNMEE, Баруун Сахарт MINURSO)-нд 2021 оны байдлаар 6 энхийг сахиулах ажиллагаанд "Цэргийн хэргийн хоёрдугаар шатны эмнэлэг" оролцуулах боломжийг тодорхойлж, санал, тооцоо танилцуулж байна.

5.2. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх

хоёрдугаар шатны эмнэлэгт тавигдах шаардлага, бүтэц

НҮБ-ын хоёрдугаар шатны эмнэлэгт тавигдах ерөнхий шаардлага (SUR) 2017, Энхийг сахиулах ажиллагаанд оролцох цэргийн багийн эзэмшилний эд хөрөнгийн тухай (COE manual) 2017, 2020 оны гарын авлага, НҮБ-ын цэргийн ажиллагаанд зориулсан хэргийн эмнэлгийн дэмжлэг (medical support manual) 2015 оны гарын авлага, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны эмнэлгийн дэмжлэг 2015 оны гарын авлага, Өндөр эрсдэлтэй цэргийн ажиллагаанд явж үүргээ осол эндэгдэлгүй амжилттай гүйцэтгэсэн нь дараа дараагийн ажиллагаанд оролцох урам зориг, итгэл найдварыг өгсөн. 2003 оноос анхны цэргийн баг нийтийн терроризмын эсрэг "Иракийн эрх чөлөө" ОУ-ын Цэргийн эвслийн ажиллагаанд оролцоноор даян дэлхийд Энхийг тогтоох үйлсэд манай улс хувь нэмрээ оруулах асуудлыг эргэжүүлсэн юм.

Цаашид НҮБ-ын ЭС ажиллагаанд цэргийн эмнэлгийн баг, цэргийн хэргийн эмнэлэг явуулж болох, НҮБ-ын цэргийн багийн хүчний тогтолцоонд бүртгүүлэх асуудлуудыг НҮБ-д тавьсан.

Энэхүү эмнэлгийг НҮБ-ын II шатны эмнэлгийн бүтэц, стандарт шаардлагад нийцүүлэн өөрчилж 68 хүний бүрэлдэхүүнтэй болгон ЗХЖШ-ын даргын зөвлөл, БХ-ын сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, ЗХ-ний Ерөнхий командлагчид танилцуулсан. АНУ-ын Номхон далайн командлалын Агаарын хүчний эмнэлгийн газартай хамтран 2009-2010 онуудад 4 удаагийн сургалтыг танхимаар болон "5 толгой дахь ЗХ-ний сургалтын нэгдсэн төв"-д эмнэлгийг дэлгэх, ажиллуулах, татан гаргах, хураах ажиллагааг хэргийн нөхцөлд зохион байгуулсан.

### ХУРАНДАА Р.ДАВААДОРЖ: НҮБ, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД ЦЭРГИЙН ХЭЭРИЙН ХОЁРДУГААР ШАТНЫ ЭМНЭЛЭГ ДЭЛГЭН БАЙРЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛСАН "ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ"-Т ХИЙСЭН ДҮН

1990 ээд оны дунд үеэс БХЯ, ЗХЖШ-ын удирдах бүрэлдэхүүний дундаас Монгол Улсын Зэвсэгт хүчний офицер, цэргийн баг, эмч, эмнэлгийн багийг НҮБ-ын Энхийг Сахиулах ажиллагаанд оролцуулах тухай санал санаачилга, ярицлагууд гарч эхэлсэн. Энэ нь нэг талаар Монгол Улсын гадаад бодлогын үндсэн тулгуур ойлголтуудын нэг тусгаар тогтнолоо улс, төр дипломатын аргаар хамгаалах бодлоготой нийцэх, нөгөө талаар 1961 онд НҮБ-д бүрэн эрхт хүйүнээр элсэн орсон орны хувьд, даян дэлхийд энх тайвныг тогтоох үйлсэд хувь нэмэр оруулах, гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэх явдал байлаа.

Хүйтэн дайны уур амьсгал төгсгөл болсон үед дайнаас бусад цэргийн ажиллагаанд Монгол цэргийг оруулах, орчин үеийн цэргийн ажиллагааны стратеги тактикт суралцах, бэлтгэх, үүрэг гүйцэтгэх замаар Зэвсэгт хүчний тасралтгүй байнгын бэлэн байдлыг хангах зэрэг шаардлагуудтай нийцсэн байлаа.

Монгол Улсын Засгийн газраас 1999 онд Энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цэргийн баг оролцуулах, тухай тогтоол гаргаж, улмаар "НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай Монгол Улсын Засгийн газар, НҮБ хоорондын санамж бичиг"-ийг байгуулсан. 2002 онд УИХ-аас "Цэрэг, цагдаагийн албан хаагч НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай" хуулийг соёрхон баталсан. Энэ нь Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох болох хувь эрх зүйн орчин бүрдсэнийг харуулах. Үүний дараа 2002 онд манай улсын Зэвсэгт хүчнээс анхны 2 энхийг сахиулагч БНАКонго Улсад явагдаж байгаа НҮБ-ын ЭС-анд цэргийн ажиллагаанд явж үүргээ осол эндэгдэлгүй амжилттай гүйцэтгэсэн нь дараа дараагийн ажиллагаанд оролцох урам зориг, итгэл найдварыг өгсөн. 2003 оноос анхны цэргийн баг нийтийн терроризмын эсрэг "Иракийн эрх чөлөө" ОУ-ын Цэргийн эвслийн ажиллагаанд оролцоноор даян дэлхийд Энхийг тогтоох үйлсэд манай улс хувь нэмрээ оруулах асуудлыг эргэжүүлсэн юм.

Цаашид НҮБ-ын ЭС ажиллагаанд цэргийн эмнэлгийн баг, цэргийн хэргийн эмнэлэг явуулж болох, НҮБ-ын цэргийн багийн хүчний тогтолцоонд бүртгүүлэх асуудлуудыг НҮБ-д тавьсан.

Энэхүү эмнэлгийг НҮБ-ын II шатны эмнэлгийн бүтэц, стандарт шаардлагад нийцүүлэн өөрчилж 68 хүний бүрэлдэхүүнтэй болгон ЗХЖШ-ын даргын зөвлөл, БХ-ын сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, ЗХ-ний Ерөнхий командлагчид танилцуулсан. АНУ-ын Номхон далайн командлалын Агаарын хүчний эмнэлгийн газартай хамтран 2009-2010 онуудад 4 удаагийн сургалтыг танхимаар болон "5 толгой дахь ЗХ-ний сургалтын нэгдсэн төв"-д эмнэлгийг дэлгэх, ажиллуулах, татан гаргах, хураах ажиллагааг хэргийн нөхцөлд зохион байгуулсан.



Эмнэлгийг НҮБ-ын ЭС-ны байнгын хүчний тогтолцоонд 2009 оны 1 дүгээр сард бүртгүүлсэн ба мөн оны 10 дугаар сард Африкийн UNAMID ажиллагаанд оролцуулж болох тухай мэдэгдлийг НҮБ-ын ЭСAG-аас авсан.

Ингээд 2010 оны 11 дүгээр сард ЗХЖШ-аас ЭМХ-ийн дарга хурандаа Р.Даваадорж миний бие, ЭСAG-ын мэргэжилтэн дэд хурандаа Д.Ариунболд, ЗХ

ХУРАНДАА Б.ЭНХ-ОД: ЦЭРГИЙН ХЭЭРИЙН II ШАТНЫ ЭМНЭЛГИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛТЭД ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ОРОЛЦОО

Агуулга:

- 1.Цэргийн төв эмнэлэг энхийг дэмжих ажиллагаанд оролцсон байдал
- 2."UNAMID" ажиллагаанд илгээсэн цэргийн алба хаагчдын статистик үзүүлэлтүүд
- 3.Цэргийн төв эмнэлгийн статистик үзүүлэлт
- 4.Энхийг дэмжих ажиллагаанд Цэргийн төв эмнэлгийн оролцох боломж
- 5.Дүгнэлт



Монгол улсын цэргийн хэзэрийн хоёрдугаар шатны эмнэлэг нь НҮБ болон Бүгд Найрамдах Судан Улсын ард иргэдийн хооронд иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх "Алтан гүүр" болж чадсан.

Шинэ коронавирусийн халдварын ажиглалт, хяналт, тусгаарлалт, эмнэлгийн тусламж үйлчилгээний үе шат

2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 11 сарын 22-ны өдрийн хугацаанд гадаадын улс орнуудаас 72 удаагийн тусгай үүргийн нислэг болон 6 удаагийн газрын татан авалтаар ирсэн эмнэлгийн тусламж шаардлагатай нийт 1582 иргэдийн хүлээн авч тусгаарлан, иргэд, үйлчлүүлэгчдэд 20 гаруй төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн.

Энхийг дэмжих ажиллагаанд

мэндийн яамтай хамтарч ажиллах гэрээ байгуулж, тус саналаа Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын удирдлагад хүргүүлэх

Дүгнэлт

- Энхийг дэмжих ажиллагаанд оролцсоноор цэргийн төв эмнэлгийн ажилтан, алба хаагчдын эмнэлгийн болон цэргийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар дээшлэн, олон талт үүрэг гүйцэтгэх чадвар сайжирч, гадаад хэлний мэдлэг нэмэгдэж, Монгол эх орон, байгууллага, гэр бүл, бие хүнийхээ үнэт зүйлийг илүү ихээр ойлгон мэдэж, ёс зүйтэй, эх оронч үзэл төлөвшин тогтож байна.
- Тэр дундаа яаралтай тусламж, аврахуйн анагаах ухааны чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлэх дадлага, чадвар сайжирч, багаар ажиллах, олон улсад цэргийн болон эмнэлгийн мэргэжлээр ажиллах туршлага хуримтлуулах, шинэлэг зүйлсийг сурч мэдэх зэрэг олон давуу талуудтай.
- Цаашид цэргийн хэзэрийн II шатны эмнэлгийн ажиллагааны өмнөх бэлтгэлд, цэргийн төв эмнэлгийн туршлагажсан хамт олон дараа үеийн шинэ залуу энхийг сахиулагч нарт мэргэжлийн сургалт, бэлтгэлийн хичээлүүдийг зааж тогтмолжуулснаар ажиллагааны газар оронд учрах эрсдэлийг бууруулна.

ХУРАНДАА Ч.Пүрэвдорж: ЦЭРГИЙН ХЭЭРИЙН II ШАТНЫ ЭМНЭЛГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛ, АЖИЛЛАГААНЫ ҮЕИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ



Агуулга:

- Хууль эрх зүйн үндэс
- "UNAMID" ажиллагааны тухай
- Цэргийн хэзэрийн II шатны эмнэлгийн ажиллагааны өмнөх олон ажиллагааны үеийн цэргийн сургалт бэлтгэл
- Ажиллагааны үеийн аюулгүй байдлыг хангах
- Холбоо, зэвсэглэл, ар тал материал техникийн хангалт

ЦЭРГИЙН ХЭЭРИЙН II ШАТНЫ ЭМНЭЛГ

НҮБ болон Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу НҮБ-ын энгийн болон цэргийн алба хаагчид, цэргийн ажиглагч нар, НҮБ-ын гэрээт болон сайн дурын ажилчин алба хаагч нарт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ орон нутгийн энгийн иргэдэд өдөр бүр үзлэг оношилгоо, зөвлөгөөг чанартай үзүүлж байгаа нь Монгол Улсын Засгийн газраас үзүүлж байгаа хүмүүнлэгийн тусламжийн нэг хэлбэр юм.

ШНЦ-ийн үндсэн үйл ажиллагаа

Цэргийн баазын шалган нэвтрүүлэх байр (цэг)-аар НҮБ-ын цэрэг, цагдаагийн алба хаагч 14852, энгийн ажилтан 9600, орон нутгийн энгийн иргэд 21555, цэргийн багийн цэргийн алба хаагч 24208, нийт 70215, "UNAMID" ажиллагааны тээврийн хэрэгсэл 6327, орон нутгийн тээврийн хэрэгсэл 360, цэргийн багийн тээврийн хэрэгсэл 16974, нийт давхардсан тоогоор 23661 тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу баазын байрлалд шалгаж нэвтрүүлсэн байна.

Ажиллагааны үеийн аюулгүй байдалд нөлөөлж байсан хүчин зүйл:

Нэгдсэн үндэсний байгууллага, Африкийн холбооны хамтарсан UNAMID энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол улсын цэргийн хэзэрийн II шатны эмнэлгийн ү зээлийн цэргийн баг нь Бүгд найрамдах Судан улсын Дарфур муж, Кабкавия тосгоны зүүн хойд хэсэгт Рванда улсын батальоны хамгаалалтанд байдаг бөгөөд Рванда улсын батальоны штаб, мотобудлагын 2 рот, түргэн байрлах хүчний ротын хамт, Иордан улсын цагдаагийн хүчжүүлсэн рот, цэргийн ажиглагч нарын баг, иргэний цагдаагийн ажиглагч нарын баг, холбоо, техник, инженерийн бүлэг зэрэг НҮБ-н ЦАХ нар болон гэрээт ажилчидтай зэргэлдээх "Хөх морь" баазад үүрэг гүйцэтгэж байна.

Дарфур мужийн ерөнхий цагийн байдал, урьдчилан тааварлах боломжгүй, тогтвортой бус ялангуяа манай цэргийн багуудын байрлах буй хойд сектор, Кабкавия суурингийн орчимд сөргөлдөгч талуудын үйл ажиллагаа идэвхтэй үйл ажиллагаа явуулсаар байна.

Кабкавия тосгоны ерөнхий цагийн байдал тогтворгүй, баазын зүүн хойд талд Арабууд зонхилсон Ал Хара суурин, урд болон зүүн урд талуудад шилжин суурьшигчид, Арабууд холилцсон Кабкавия суурин байрладаг ба энэхүү сууринд аливаа төрлийн хүчирхийлэл, дээрэм, тонуул гардаг төдийгүй овгуудын хоорондын мөргөлдөөн удаа дараа гарч байсан нь Цэргийн багийн аюулгүй байдалд ихээхэн сөргөөр нөлөөлж байсан.

ХОШУУЧ О.ГЭРЭЛМАА: ЭМНЭЛГИЙН ЦЭРГИЙН БАГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН, ҮНДСЭН БОЛОН ӨӨРИЙГӨӨ ХАНГАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭМ, МАТЕРИАЛ ХЭРЭГСЛИЙН НӨХӨН ХАНГАЛТ



Агуулга:

- 1. Эрх зүйн үндэслэл
- 2. Эмнэлгийн цэргийн багийн бүтэц, орон тоо
- 3. Эмнэлгийн мэргэжилтний нөхөн хангалт, оролцоо
- 4. Харилцан ойлголцлын санамж бичгийн төлөвлөлт, хэрэгжилт
- 5. Үндсэн болон өөрийгөө хангах тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын байдал
- 6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоон үзүүлэлт, зардал
- 7. Нөхөн төлбөр, үр ашгийн үзүүлэлт
- 8. Цэргийн багуудад тулгамдаж байсан зарим асуудал

9. Дүгнэлт

Үр дүн: НҮБ-ын стандарт, шаардлагад нийцсэн 68 хүнтэй Цэргийн хэзэрийн II шатны эмнэлгийн 8 ээлжлэй ажиллагааны газар оронд илгээхэд 8,1 тэрбум төгрөгийн хангалтыг зохион байгуулж, Зэвсэгт хүчний хөгжлийн санд 38,6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг НҮБ-ын нөхөн төлбөрийн сангаас бүрдүүлж ажилласан.

Дүгнэлт:

Манай улсаас НҮБ-ын энхийн ажиллагаанд цэргийн хэзэрийн II шатны эмнэлгийг анх удаа оролцуулснаар Зэвсэгт хүчний төдийгүй Монгол Улсын эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэшил, ур чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ цэргийн эмнэлгийн хангалтыг НҮБ-ын стандартын шаардлагын түвшинд зохион байгуулах чадварыг бүрдүүлж, НҮБ-ын ЭСА-нд цэргийн хэзэрийн II шатны эмнэлэг, хүмүүнлэгийн тусламж, үйлчилгээг дотоодын үймээн самуунтай бус нутгийн ард иргэдэд үзүүлж, НҮБ-ын болон Монгол Улсын өмнө хүлээсэн үүрэг амжилттай биелүүлжээ.

ЭСА-нд Цэргийн хэзэрийн II шатны эмнэлгийг оролцуулснаар эмнэлгийн мэргэжилтний дунд Энхийг сахиулагчдын тоог нэмэгдүүлж, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал тулхцац болж, эмнэлгийн цэргийн багийн үндсэн болон өөрийгөө хангах тоног төхөөрөмжийн нөхөн төлбөрөөр Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг 30,5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, бусад ЭСА, олон улсын цэргийн хамтарсан сургалт, дадлагын хангалтыг зохион байгуулахад хувь нэмрээ оруулж чадсан байна.

ДЭД ХУРАНДАА П.САМБУУЖАНЦАН: БҮГД НАЙРАМДАХ СУДАН УЛСЫН ДАРФУР МУЖИД ЯВАГДСАН НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА, АФРИКИЙН ХОЛБООНЫ ХАМТАРСАН "UNAMID" ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ХОЙД БҮСИЙН ЭМНЭЛГИЙН ШТАБЫН ОФИЦЕРУУДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛТ, ЦЭРГИЙН БАГИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

Агуулга:

- Эрх зүйн үндэслэл
  - Хойд бүсийн командлал дахь эмнэлгийн штабын офицерийн үүрэг гүйцэтгэх үеийн онцлог
  - Хүчний командлал дахь эмнэлгийн хэлтсийн штабын офицерийн үүрэг гүйцэтгэх үеийн онцлог
  - Цэргийн баг, эмнэлгийн штабын офицеруудын харилцан ажиллагаа
  - Дүгнэлт
- Цэргийн баг, эмнэлгийн штабын офицеруудын харилцан ажиллагаа
- Монгол Улсын цэргийн багууд ээлж солилцох үед шинээр ирэх багийг угтан авч, үүргээ гүйцэтгээд буцаж байгаа багийн бие бүрэлдэхүүнийг үдэх ажлыг хамтран зохион байгуулах



багтай хамтран зохион байгуулж ажилласан байна.

Судан улсын Дарфур муж дахь Африкийн холбоо болон НҮБ-ын хамтарсан UNAMID ажиллагааны Цэргийн хүчний Төв штабын J3/Ажиллагааны хэлтсийн даргын орлогч, хэлтсийн дарга, ажиллагааны ахлах офицерын үүргийг гүйцэтгэсэн хурандаа М.Батчулуун, хурандаа Д.Мягмаржав, хурандаа Б.Бат-Эрдэнэ, Хурандаа С.Ванчинхүү, дэд хурандаа Ж.Батбаяр, дэд хурандаа Т.Мөнхжаргал, дэд хурандаа Ж.Хоролсүрэн нарын шилдэг офицерууд ажиллаж байсан юм.

Эмнэлгийн штабын офицерууд нь дараах үүргийг мэргэжлийн түвшинд амжилттай гүйцэтгэсэн.

Дүгнэлт

- 1. UNAMID ажиллагаанд эмнэлгийн штабын офицерууд үүрэг гүйцэтгэх хугацаандаа бүсийн эмнэлгийн штабын офицероос Хүчний командлалын эмнэлгийн хэлтсийн дарга хүртэлх хариуцлагатай албан тушаалуудад ажиллаж, үүргээ нэр төртэй биелүүлж, мэргэжлийн болон хэлний ур чадвараа улам дээшлүүлж, Олон улсын байгууллагад ажиллах туршлага хуримтлуулсан юм.
- 2. Монгол Улсын цэргийн эмч нар энхийг дэмжих ажиллагаанд эмнэлгийн удирдах түвшин албан тушаалын үүрэгт ажлыг гүйцэтгэх боломжтойг харуулсан байна.
- 3. Монгол улсын засгийн газар, НҮБ-ын хооронд "Харилцан ойлголцлын санамж бичиг"-г заагдсан үүргээ биелүүлэхэд эмнэлгийн штабын офицерууд нь Цэргийн хэзэрийн II шатны эмнэлгийн багтайгаа ажил үүргийн хувьд харилцан мэргэжлийн өндөр түвшинд ажилласан болно.

II шатны эмнэлгээр үйлчлүүлсэн НҮБ-ын мандаттай ажилтан, цэрэг, цагдаагийн алба хаагчид болон Кабкавия суурингийн энгийн ард иргэдийн өвчлөлийн судалгааг I шатны эмнэлгийн статистиктай нэгтгэж статистик судалгааг сар бүр гаргаж, Хүчний штабын эмнэлгийн албанд илгээх;

Өвчтөн, шархтныг татан гаргах ажиллагааг Хөдөлгөөний хяналтын алба, Хүчний штабын эмнэлгийн хэлтэстэй хамтран зохион байгуулах;

Халдварт өвчин гарсан тохиолдолд Халуун орны халдварт өвчний талаарх сургалтыг зохион байгуулах зэрэг үзлэг хийж; Ажиллагааны төв штабт ажиллагааны бэлэн байдлын талаар статистик мэдээ, мэдээлэл илгээх;

Бүсийн командлагчийн албан айлчлалын бүрэлдэхүүний хамт цэргийн багтаа айлчлах;

Эмнэлгийн бэлэн байдлын мэдээ, мэдээллийг нэгтгэн Хүчний штабын эмнэлгийн болон бусад холбогдох албанд илгээх; Хүмүүнлэгийн ажлыг эмнэлгийн

ХОШУУЧ А.ГАНБАТ: АЖИЛЛАГААНЫ ГАЗАР ОРОНД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ОНЦЛОГ, ТУРШЛАГА, СУРГАМЖ, МОНГОЛ ОРОНД ТОХИОЛДДОГҮЙ ЗАРИМ ТӨРЛИЙН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭ

Агуулга:

- Монголын II шатны эмнэлгийн үйл ажиллагаа (I-VIII ээлж);
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний онцлог тохиолдлууд;
- Цэргийн багийн үүрэг гүйцэтгэлтэд гарсан хүндэрэл, бэрхшээлүүд;
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх зарим туршлага, сургамж;
- Хүмүүнлэгийн ажиллагаа болон сургалт бэлтгэлжилт;
- Монгол улсад тохиолддоггүй халуун бүсийн өвчлөлүүд;
- Дэвшүүлэх санал;
- Дүгнэлт.



Э м н э л г и й н тусламж үйлчилгээний талаарх зарим туршлага, сургамж

Х ү м ү ү н л э г и й н болон иргэн цэргийн харилцааны хүрээнд ажлын өдрүүдэд орон нутгийн иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж байсан нь цэргийн багийн эмч, мэргэжилтнүүдэд Монгол оронд ховор тохиолдох, өмнө нь тохиолдол бүртгэгдэж байгаагүй, халуун бүсийн орны өвөрмөц өвчин, эмгэгийг таньж мэдэх, оношлох, эмчлэх, хянах бололцоог олгон туршлага хуримтлуулсан. Жишээлвэл: / Хумхаа, Шар чирээ, Эбола вирусын халдвар, гэдэсний хавдар, Шистосомиаз, Бамбай булчирхайн тархмал болон хордлогот бахуурын өвөрмөц хэлбэрүүд... Иймд ажиллагааны газар орны онцлог, нийтлэг өвчлөлийн талаар үүрэг гүйцэтгэх эмч, эмнэлгийн ажилчид мэргэжлийн онцлогоос үл хамааран дээрх өвчлөлийн талаар өргөн хүрээний мэдлэг, мэдээлэл хуримтлуулж, судалсан байх шаардлагатай байна.

Судан улсад Хумхаа, Шар чирээ, Тэмбүү, ДОХ, Урвах тахал, Сүрьеэ, Эбола вирусын халдвар, гэдэсний хижиг, сальмонеллез, А,В,С хэлбэр элэгний цочмог үрэвсэлт өвчнүүд нутагшмал голомттой байдаг тул тус оронд энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж буй цэргийн багийн бие бүрэлдэхүүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүд болсоор байдаг. Орон нутгийн иргэд гал болон хүйтэн зэвсгээр гэмтсэн, авто осолд өртсөн өвчтөнүүд тусламж авахаар их хэмжээгээр ирдэг учир эмнэлгийн

ажилчид эмнэлгийн тусламж үзүүлэх, ажилбар хийх, цустай харьцах үед өөрсдийн аюулгүй байдлыг дээд зэргээр сахин болгоомжтой ажиллан, хамгаалах хэрэгсэлээ тогтмол, зөв, аюулгүй хэрэглэх нь зарим үед тусламж үзүүлэхээс илүү чухал гэдэгт анхаарах хэрэгтэй.

Халуун болон хүйтэн зэвсгийн гэмтэл, мэс заслын яаралтай тусламж үйлчилгээ, мэс засал гэмтлийн хөгжлийн түвшин, ажиллагааны газар оронд эх орны нэр хүндийг өндөрт өргөх, хамгаалах зэрэг шаардлагын улмаас ажиллагаанд явах бие бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтанд анхаарч мэдлэг туршлагатай түшиг болох хэсгийн тоо, боломжийг тус ажиллагааны хугацаанд тааруулан урьдчилан харж жигд хуваарилах нь сүүлийн ээлжүүдийн бүрэлдэхүүнээс харахад бодуштай санагдсан.

Суданы засгийн газрын цэрэг, цагдаа орон нутгийн иргэд галт зэвсгийн гэмтэл, шархдалтын улмаас амь насны заалтаар манай эмнэлгээр үйлчлүүлэх тохиолдолд хүнд, амь тэнсэн тохиолдлуудад эмнэлгийн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх шаардлагатай бөгөөд хэрэв шархтан болон өвчтөний амь нас эрсэдсэн тохиолдолд тэдгээрийн ар гэр болон төрөл төрөгсөд зөвөөр, сайн ойлгуулж эмнэлгээр үйлчлүүлэх хүсэлт, хагалгаа ажилбар хийлгэх хүсэлтийг бөгүүлэн гарын үсгээр баталгаажуулах зайлшгүй шаардлагатай. Эмнэлгийн тусламж үйлчилгээ таатай бусаар төгссөн тохиолдолд НҮБ, НҮБ-ийн ЦАХ-дын эсрэг үйл ажиллагаа явуулах, амь нэхэх, мөнгөн төлбөр нэхэх зэрэг хандлага гаргах эрсдэлд хүргэж болзошгүй. Ямар ч эрсдэлгүй төлөвлөгөөт хагалгаа гэж хаана ч байдаггүй. Хэдийгээр МОУ-д тусгагдаагүй ч орон нутгийн иргэдийг орон нутгийн засаг захиргаа, иргэн ойлгуулж харилцааны холбогчийн хүсэлтээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд олон омуудыг хооронд нь ялгаж таних аргагүй тул эмнэлгийн тусламж үйлчилгээг харилцан ялгаварлахгүйгээр эмчийн ёс зүйг сахин, хүнлэг энэрэнгүйгээр, тэгш хүртээмжтэй

үзүүлэх шаардлагатай /орчуулагч нартай зөв боловсон харилцах хэрэгтэй/.

Дүгнэлт

UNAMID" ажиллагааны хэрэгцээ шаардлага, эмнэлгийн барилгын талбай, өрөө, тасалгаа хүрэлцээтэй тул цаашид хоёрдугаар шатны эмнэлгийн үйл ажиллагаа явуулж буй одоогийн цэргийн багийн бүтэц дээр нэмж нүд, эмэгтэйчүүд, мэдрэлийн мэс заслын эмч нар, цэргийн багийн удирдлагад ажиллагааны болон иргэн цэргийн харилцааны офицер зэрэг албан тушаалтнуудыг нэмж, компьютер томографийн аппарат болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр цэргийн багийг нөхөн хангаснаар II шатны эмнэлгийг III шатны эмнэлэг болгож, Монгол Улсын Засгийн газарт орох нөхөн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой тухай үед дурдаж байсныг цаашид бодуштай.

Монгол Улсын Зэвсэгт хүчний Цэргийн хэзэрийн хоёрдугаар шатны эмнэлэг "UNAMID" ажиллагаанд оролцох хугацаандаа өөрсдийн хүчээр эмнэлгийн бүрэн иж бүрдэл байрыг барих, үүрэг гүйцэтгэх баазыг тохижуулахаас эхлээд НҮБ-ын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж энхийг сахиулах үйлсэд монгол цэргийн ариун мөртэй зам мөрийг тог томруулан дэлхий дхиннаа харуулахад чухал хувь нэмрээ оруулсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.

Хойд секторын олон нийттэй харьцах албанаас 3 хүний бүрэлдэхүүнтэй баг Монгол улсын цэргийн хэзэрийн II шатны эмнэлэгт айлчлан, зуран авалт хийж эмнэлгийн үйл ажиллагааг харуулсан богино хэмжээний баримтат кино хийж 2012 оны XII сарын 19-ны өдөр "You-Tube" сайтад "The people's hospital" нэртэй өргөтгөлөөр интернэтэд тавьсан явдал нь энэ эмнэлгийн нэр хүнд, ач тус, гүйцэтгэсэн үүргийн зэх зухаас нь харуулсан үйл явдал болсныг дурсахад нэн таатай бөгөөд "Ард түмний эмнэлэг" гэсэн гуравхан үгээр л илэрхийлэхэд хангалттай биз ээ.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ

- Батлан хамгаалах яам
- Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС

- "Соёмбо" сонин
- "Дуулга" студи

- \* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
- \* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
- \* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)